



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн  
хороодыг шинэчлэн байгуулах тухай**

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэг, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.21 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай:

А.Анар	Хорооны дарга
Д.Баянзул	Хорооны гишүүн
Р.Гандиймаа	Хорооны гишүүн
Г.Лхамдулам	Хорооны гишүүн
С.Лхагвадорж	Хорооны гишүүн

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай:

Р.Гандиймаа	Хорооны дарга
А.Анар	Хорооны гишүүн
Л.Наранчимэг	Хорооны гишүүн

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ч.Дондогмаа	Хорооны дарга
А.Анар	Хорооны гишүүн
Р.Гандиймаа	Хорооны гишүүн

4. Хороодын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ТУЛГА

1522012224



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг  
түр томилох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5, 76 дугаар зүйлийн 76.1.18, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.22, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 07 дугаар "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай" тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 05/8934 дугаар албан тоот, мөн тус газрын 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 05/9890 дугаар албан тоот, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн Д.Энхбаатар, А.Батпүрэв нарын оронд Нэр дэвшүүлэх хорооны сонгон шалгаруулалтаар шалгарч, холбогдох хууль, журамд заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний шаардлагыг хангасан С.Лхагвадорж, Г.Лхамдулам нарыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн нөхөн сонгууль хүртэл хугацаанд түр томилсугай.
2. Энэхүү тогтоолд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /А.Анар/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ТУЛГА

1523010037